



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН
ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДАД ЦАГ ҮЕИЙН
ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

2017 оны 03 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шалгалтын үндэслэл, зорилго

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 70.1.6. мөн хуульд нийцүүлэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Хяналт шалгалтын журам”-ын 6, 9.3.2, 9.4, 13.1.1, 13.1.2 дугаар зүйл, “Гишүүнчлэлийн журам”-ын 4. болон 5. дугаар зүйл, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 2.1.4. дэх заалтуудыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн үнэт цаасны компаниудад газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь гишүүн үнэт цаасны компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж хууль журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны чадавхыг үнэлж цаашид хамтарч хэрэгжүүлэх ажлын чиг хандлагыг тодорхойлоход энэхүү газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Шалгалтын ажлын чиглэл

Гишүүн компанийд “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Хяналт шалгалтын журам” болон “Гишүүнчлэлийн гэрээн”-нд заасны дагуу дараах чиглэлээр газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Хууль тогтоомж, журам, гэрээний үүргийн хэрэгжилт;
2. Гишүүн компанийн ажилтны ёс зүйн дүрмийн хэрэгжилт;
3. “Гишүүнчлэлийн журам”-д заасан шаардлага, шалгууруудыг ханган ажиллаж байгаа эсэх;
4. Мэдээ, мэдээллээ тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэх;
5. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлсэн эсэх;
6. Харилцгчийн захиалга хүлээн авах, биелүүлэх үйл ажиллагаа;
7. Дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаа;
8. Өөрийн компанийн дүрэм, журамд орсон өөрчлөлтүүд;
9. Удирдлага болон боловсон хүчний талаарх мэдээлэл;
10. Компанийн хаяг, байршил түүнд орсон өөрчлөлт;

Гурав. Шалгалт хийх ажлын бүрэлдэхүүн, эрх, үүрэг

Газар дээрх хяналт шалгалтыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хяналт, Зохицуулалтын Газрын

Хяналт шинжилгээний
албаны ахлах мэргэжилтэн

Д.Баттулга

Гишүүн үнэт цаасны компани
хариуцсан мэргэжилтэн

С.Шинэболд
Э.Шинэтуяа

Арилжааны хяналт
хариуцсан мэргэжилтэн

Б.Наранцэцэг
Д.Оргилмаа

нарын бүрэлдэхүүнтэйгээр 2017 оны 04 сарын 10 өдрөөс эхлэн 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд ажлын өдрүүдэд хийж гүйцэтгэх ба гишүүн компанийн ажлын байранд очиж шалгалт хийх тухай нэг өдрийн өмнө тухайн компанийд мэдэгдэнэ.


Газар дээрх хяналт шалгалт хийж буй мэргэжилтэн нь “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 70.1.6 дах заалт болон мөн хуульд нийцүүлэн гаргасан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Хяналт шалгалтын журам”-ын 10, 11, 12 дугаар зүйлүүдийг удирдлага болгон газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүнг гаргах, танилцуулах

Хяналт шалгалтын мэргэжилтэн нь хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засаж сайжруулах талаар хугацаатай үүрэг, албан даалгавар өгөх, гүйцэтгэлийг хангуулах, холбогдох журам гэрээнд заасан хариуцлага ногдуулах ажлыг хангана.

Хяналт шалгалтын ажлыг энэхүү удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсний дараа шалгалт хийсэн тухай ажлын тайланг гаргаж “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн удирдлагуудад танилцуулна. Хууль журамд заасан ноцтой зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд “Санхүүгийн зохицуулах хороо”-ны хуралдаанд хэлэлцүүлэхээр санал оруулж болно.

ТАНИЛЦСАН:
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ


2017.01.31.

А.МОНХБАЯСГАЛАН